

БАТЛАВ.
БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Ц.УРАНБЯМБА*
 2021 оны 10 дугаар сарын 13 -ны өдөр

АЙМГИЙН ЕБС-ИУДАД “СУРГУУЛЬД СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ”-НИЙ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛ, ХУВААРЬ

2021.10.13

ЗОРИЛГО: Суралцагчдын эзэмшвэл зохих агуулгын хоцрогдлыг бүх анги, судлагдахуунаар нийт суралцагчдыг хамруулан оношилж, суралцагчдийн хоцрогдлыг нөхөх, арилгах арга замыг сургуулийн түвшинд тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад мэдээллээр хангахад сургуульд суурилсан үнэлгээний зорилго оршино.

ЗОРИЛТ: Сурагч, багшийн хэрэгцээ болон сургуулийн өнөөгийн байдлыг тодорхойлох, хичээл, сурлагын хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөөнд тодотгол хийн, хэрэгжүүлэх

ХАМРАХ ХҮРЭЭ: Сургуульд суурилсан үнэлгээнд аймгийн ЕБС-ийн 2-12 дугаар ангийн бүх суралцагчид хамрагдана.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: Аймгийн БСУГ-ын удирдлага дор сургууль бүр бие даан зохион байгуулна.

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА: 2021 оны 10 дугаар сарын 13-28-ны өдрүүдэд

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ:

№	Түвшин	Хичээлийн нэр	Анги	Үнэлгээ авах сар, өдөр	Эхлэх цаг	Гүйцэтгэх хугацаа
1	Бага боловсрол	Монгол хэл	2-5	10 сарын 15	9.00	35 минут
2		Математик	2-5	10 сарын 18	9.00	35 минут
3		Хүн ба байгаль	5-6	10 сарын 20	9.00	35 минут
4		Хүн ба нийгэм	5-6	10 сарын 22	9.00	35 минут
5		Хүн ба орчин	2-3	10 сарын 25	9.00	35 минут
6		Эрүүл мэнд	4-5	10 сарын 26	9.00	35 минут
7		Биеийн тамир	3-5	10 сарын 19	9.00	35 минут
8		Дүрслэх урлаг	3-5	10 сарын 21	9.00	35 минут
9		Хөгжим	3-5	10 сарын 27	9.00	35 минут
1	Суурь боловсрол	Математик	6-9	10 сарын 15	9.00	70 минут
2		Монгол хэл	6-9	10 сарын 18	9.00	70 минут
3		Физик	7-9	10 сарын 19	9.00	35 минут
4		Хими	7-9	10 сарын 20	9.00	35 минут
5		Биологи	7-9	10 сарын 21	9.00	35 минут
6		Түүх	7-9	10 сарын 22	9.00	35 минут
7		Нийгэм судлал	7-9	10 сарын 25	9.00	35 минут
8		Газар зүй	8-9	10 сарын 26	9.00	35 минут
9		Англи хэл	6-9	10 сарын 27	9.00	35 минут
10		Орос хэл	7-9	10 сарын 28	9.00	35 минут
11		Биеийн тамир	6-9	10 сарын 29	9.00	35 минут
12		Эрүүл мэнд	6-9	10 сарын 28	9.00	35 минут
13		Хөгжим	6-9	10 сарын 19	14.00	35 минут

14		Дүрслэх урлаг, дизайн технологи	6-9	10 сарын 20	14.00	35 минут
1	Бүрэн дунд боловсрол	Математик	10-12	10 сарын 15	9.00	70 минут
2		Монгол хэл	10-12	10 сарын 18	9.00	60 минут
3		Хими	10	10 сарын 20	9.00	35 минут
			11-12	10 сарын 20	9.00	60 минут
4		Биологи	10	10 сарын 21	9.00	35 минут
			11-12	10 сарын 21	9.00	60 минут
5		Физик	10	10 сарын 19	9.00	35 минут
			11-12	10 сарын 19	9.00	60 минут
6		Түүх	10	10 сарын 22	9.00	35 минут
			11-12	10 сарын 22	9.00	60 минут
7		Нийгэм судлал	10	10 сарын 25	9.00	35 минут
			11-12	10 сарын 25	9.00	60 минут
8		Газар зүй	10	10 сарын 26	9.00	35 минут
			11-12	10 сарын 26	9.00	60 минут
9		Англи хэл	10-12	10 сарын 26	9.00	60 минут
10		Орос хэл	10-12	10 сарын 27	9.00	60 минут
11		Эрүүл мэнд	10-12	10 сарын 28	9.00	35 минут
12		Дизайн зураг зүй, технологи	10-12	10 сарын 20	14.00	35 минут
13		Биеийн тамир	10-12	10 сарын 19	14.00	35 минут
14		Хөгжим	10	10 сарын 19	14.00	35 минут

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Бэлтгэл ажлын хүрээнд:

- 1.1. Сургууль бүр хичээл тус бүрд шалгалтын материалыг засаж, оноожуулах мэргэжлийн багш нарын багийг захирлын тушаалаар томилно.
- 1.2. Ерөнхий боловсролын сургууль нь аймгийн БСУГ-аас ирүүлсэн сэдэв, даалгаврыг сурагчдын тоогоор шалгалт авахын өмнөх өдөр хэвлэн олшруулна.
- 1.3. Сургуульд суурилсан үнэлгээний сэдэв, даалгаврын нууцлалыг БСУГ, сургуулийн захирал бүрэн хариуцаж ажиллана.
- 1.4. Сургуульд суурилсан үнэлгээний зорилго, ач холбогдол, хэрэглээг багш, суралцагчид, эцэг эхчүүдэд ойлгуулах, мэдээлэл өгөх ажлыг урьдчилан зохион байгуулна.
- 1.5. Сургуульд суурилсан үнэлгээний үр дүн бодитой гарах, үнэн зөв явагдахыг сургуулийн захирал, сургалтын менежер болон захирлын тушаалаар томилогдсон мэргэжлийн баг бүрэн хариуцна.

2. Зохион байгуулалтын хүрээнд:

- 2.1. Аймгийн БСУГ, Арга зүйн зөвлөл сум, орон нутагт сургуульд суурилсан үнэлгээ зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар ханган ажиллана.
- 2.2. Сургуулиуд сургуульд суурилсан үнэлгээг 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны хооронд БСУГ-аас хүргүүлсэн чиглэл, хуваарийн дагуу зохион байгуулна.
- 2.3. Сургуульд суурилсан үнэлгээг зохион байгуулахдаа хичээл, сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байхаар зохицуулалт хийхэд анхаарна.

3. Материалыг засах, оноожуулах ажлын хүрээнд:

- 3.1. Сургуулийн захирлын тушаалаар томилогдсон үнэлгээний ажлыг зохион байгуулах багш нар БҮТ- өөс өгөгдсөн сэдэв, даалгаврыг засаж, оноожуулах аргачлал, зааврын дагуу хүүхэд нэг бүрийг үнэлж дүн оноог гаргана.
- 3.2. Материалыг засаж оноожуулсан мэдээллийг өгөгдсөн загварын дагуу сургуулийн хэмжээнд нэгтгэж, бага боловсролын нэгтгэлийг Ц.Уранбямба, суурь боловсролыг А.Мөнхтуяа, БДБ-ыг Г.Цэрэнчимэд нарт тус тус **файлуудыг өөрийн сургуулийн нэрээр нэрлэн хадгалж, өөрсдийн жимэйл хаягаар шалгалт авснаас хойш ажлын 3 хоногт багтаан ирүүлнэ.**
- 3.3. Аймгийн Боловсрол соёл урлагийн газар аймгийн 19 сургуулийн дүнг нэгтгэж загварын дагуу 2021 оны 11 дүгээр сарын 08- ны дотор БҮТ-д хүргүүлнэ.

ҮР ДҮНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

1. Боловсролын үнэлгээний төв улсын хэмжээний нийт сургуулийн суралцагчдын даалгаврын гүйцэтгэлд шинжилгээ хийж, БШУЯ болон бусад мэргэжлийн байгууллагуудад ерөнхий тайланг хүргүүлнэ.
2. Боловсролын үнэлгээний төв “Сургуульд суурилсан үнэлгээ”-ний үр дүнгээр өгөгдлийн сан бүрдүүлэн <http://ch.stat.eec.mn/> цахим статистик тайлангийн системд оруулна.
3. Статистик тайлангийн системээс сургууль бүр өөрийн эрхээр нэвтрэн орж, сургуульд суурилсан үнэлгээний ерөнхий үр дүн, даалгавар бүрийн шинжилгээний талаарх мэдээллийг харна.
4. Сургуульд суурилсан үнэлгээний үр дүнд аймгийн Боловсрол соёл урлагийн газар дүн шинжилгээ хийж нэгдсэн, тайлан зөвлөмжийг судлагдахуун, сургууль тус бүрээр гарган сургуулиуддаа хүргүүлнэ.
5. Сургуульд суурилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан аймгийн Боловсрол соёл урлагийн газар, Ерөнхий боловсролын сургууль тус бүр хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлнэ.

БОЛОВСРУУЛСАН:

БОЛОВСРОЛ СОЁЛЫН АЛБАНЫ ДАРГА

Л.ОЮУНБАЯР